



ШУТИС-ийн Захирлын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн тушаалын нэгдүгээр хавсралт

“ИНЖЕНЕРИЙН ШИЛДЭГ ШИЙДЭЛ” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

СЭДЭВ: ГУДАМЖ ТАЛБАЙН ДАГТАРШСАН ЦАС, МӨС ЦЭВЭРЛЭХ ТӨХӨӨРӨМЖ

Уралдааны зорилго:

“Монгол инженер – 2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Монгол инженерүүдийн зохион бүтээлтийг дэмжих зорилготой тус уралдаан нь энэ удаад зам талбайн гадаргууд хуримтлагдаж дагтаршсан цас, мөсийг цэвэрлэх төхөөрөмжийг инженерийн шийдэлд (загвар, төсөл, тооцоо, технологийн процесс) тулгуурлан зохион бүтээх санааг шалгаруулах ба зохион бүтээгчдийн шилдэг шийдлийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэхэд оршино.

Уралдаанд оролцох бүтээл, төрөл:

Зам талбайн гадаргууд хуримтлагдаж дагтаршсан цас, мөсийг цэвэрлэх төхөөрөмжийг зохион бүтээх, санаа шийдлийг төхөөрөмжийн ашиглах хэлбэр, хүчин чадлаас хамааран дараах 2 төрлөөр шалгаруулна.

“Төхөөрөмж 1” - Машин, механизмд холбогдон ажиллах зориулалттай төхөөрөмж

“Төхөөрөмж 2” - Гар аргаар ашиглах, ажиллуулах боломжтой багаж

Уралдааны хамрах хүрээ:

- Монгол улсын их дээд, сургуулийн оюутнууд, инженер, багш, судлаач, зохион бүтээгчид багийн зохион байгуулалттай оролцоно.

Багийн бүрэлдэхүүн:

- Баг тус бүр 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Багийн бүрэлдэхүүнд инженерийн чиглэлээр суралцдаг оюутан хамрагдсан байна.

Шагнал, урамшуулал:

Сэдвийн хүрээнд ирүүлсэн бүтээлүүдийг төрөл тус бүрээр шалгаруулж урамшуулна.

- “Төхөөрөмж 1” төрөлд оролцогчийн шилдэг 1 бүтээл* - 3.000.000 төгрөг
- “Төхөөрөмж 2” төрөлд оролцогчийн шилдэг 1 бүтээл - 2.000.000 төгрөг
- *“Төхөөрөмж 1” төрөлд оролцогчийн шилдэг бүтээлийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор “Монгол инженер - 2024” арга хэмжээний “Инженерийн ур чадвар” тэмцээний ажлын даалгавар болгон хөгжүүлнэ.

Уралдааны хугацаа:

- Материал хүлээн авах сүүлийн хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл

Уралдаанд материал ирүүлэх:

- Уралдааны материалыг www.google.form хаягаар маягтын дагуу ирүүлнэ.

Уралдаан зохион байгуулагч:

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо

Уралдааны талаар мэдээлэл, тодруулга авах хаяг:

ШУТИС-ийн Инновац, технологи дамжуулалтын төв

И-мэйл: itto@must.edu.mn

---oOo---

БАТЛАВ. ШУТИС-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Д.ЦОЛМОНБААТАР

"ИНЖЕНЕРИЙН ШИЛДЭГ ШИЙДЭЛ" УРАЛДААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

Даалгаврын нэр: ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ДАГТАРШСАН ЦАС, МӨС ЦЭВЭРЛЭХ
ТӨХӨӨРӨМЖ ЗОХИОН БҮТЭЭХ ШИЙДЭЛ, САНАА БОЛОВСРУУЛАХ

Дагтаршиж, мөстсөн автомашины болон явган хүний зам, талбай цэвэрлэх төхөөрөмжийг зохион бүтээх шийдлийг дараах 2 төрлөөр хүлээн авна.

1. Автомашины зам, нийтийн талбайн дагтаршсан цас, мөс цэвэрлэх төхөөрөмж
2. Явган зам талбайн цас цэвэрлэх бага оврын төхөөрөмж, багаж

Шийдэл боловсруулагч баг нь аль нэг төрөлд эсвэл 2 төрөлд нэгэн зэрэг санал, шийдэл дэвшүүлж болно.

НЭГ. ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСӨӨЛӨЛ

1. Автомашины зам, нийтийн талбайн дагтаршсан цас, мөс цэвэрлэх төхөөрөмж
 - Bobcat S650 маркийн механикжсан тээврийн хэрэгсэлд суурилуулан ашиглах боломжтой байх
 - Төхөөрөмжийн ашиглалтын үзүүлэлтийг тооцоход шаардлагатай өгөгдлийг Bobcat S650 маркийн тээврийн хэрэгслийн техникийн үзүүлэлтээс авна.
 - Автомашины зам, зогсоол, нийтийн талбайд зориулагдсан байх



2. Явган зам талбайн цас цэвэрлэх бага оврын төхөөрөмж, багаж

- Явган хүний зам талбайн цас цэвэрлэхэд зориулагдсан байх
- Дагтаршсан цас мөс цэвэрлэх шаардлагыг хангасан байх
- Механикжсан байх



ХОЁР. ШАЛГАРУУЛАХ НӨХЦӨЛ

- Судалгаа хийгдсэн байдал
- Хийцийн зураг төсөл, тооцоо, симуляц хийсэн байдал
- Өөрийн өртгийн тооцоо
- Илтгэл танилцуулга (2 минут видео)